



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589  
E-mail: info@mecs.gov.mn, http://www.mecs.gov.mn

2016.11.23 № 3/3632  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН  
ГАЗАР, АЙМГИЙН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА  
НАР ТАНАА

**Гүнзгийрүүлсэн сургалтын  
тухай**

Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар "14.6.Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална." гэж заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн гүнзгийрүүлсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж байсан бол Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар дээрх заалтад өөрчлөлт орсноор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүнзгийрүүлсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг баталгаажуулахгүй болсон.

Иймээс Бага, дунд боловсролын тухай хуулийн "14.11.Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно." гэж заасны дагуу тус яам дээр дурьдсан нийтлэг шаардлагыг тогтоох хүртэлх хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1 дүгээр хэсэгт заасны дагуу гүнзгийрүүлсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар баталгаажуулна.

Хүндэтгэсэн,

БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ ДЭРДЭНЭЧИМЭГ

